

АРБИТРЫН АЖИЛЛАГААГ ТҮРГЭВЧИЛСЭН ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэгдүгээр зүйл. Журмын зорилго

1.1. Энэхүү журмын зорилго нь эрх зүйн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой бага үнийн дүнтэй маргааныг Улаанбаатар хотын Худалдааны Танхимын дэргэдэх Арбитр (цаашид “Арбитр” гэх) шуурхай хянан шийдвэрлэх журмыг тогтооход оршино.

Хоёрдугаар зүйл. Бага үнийн дүнтэй маргаан

2.1. “Бага үнийн дүнтэй маргаан” гэж нэхэмжлэлийн үнэ нь тавин сая төгрөгөөс доош үнийн дүн бүхий маргааныг хэлнэ.

Гуравдугаар зүйл. Арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулах үндэслэл

3.1. Дараах шаардлагыг хангасан тохиолдолд арбитрын бүрэлдэхүүнийг бүрдэхээс өмнө талуудын аль нэг нь эсхүл талууд арбитрын ажиллагааг түргэвчилсэн журмын дагуу явуулах хүсэлтээ арбитрт гаргана:

- 3.1.1. нэхэмжлэлийн үнийн дүн нь тавин сая төгрөгөөс доош байх;
- 3.1.2. талууд харилцан тохиролцсон байх;
- 3.1.3. маргааныг шуурхай шийдвэрлэх шаардлага үүссэн.

3.2. Арбитрын дарга энэ журмын 3.1-д заасан хүсэлт болон талуудын байр суурийг харгалзан үзсэний үндсэн дээр арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулах эсэхийг шийдвэрлэнэ.

Дөрөвдүгээр зүйл. Арбитрч, түүнийг томилох, татгалзан гаргах

4.1. Арбитрын дарга өөрөөр шийдвэрлээгүй бол тухайн маргааныг нэг арбитрч хянан шийдвэрлэнэ.

4.2. Арбитрын дарга тухайн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулах нь зүйтэй гэж шийдвэрлэсэнээс хойш ажлын нэг өдрийн дотор багтаан талууд арбитрчаа томилно.

4.3. Талууд арбитрчаа арбитрын санал болгосон нэрсийн жагсаалтаас томилж болно.

4.4. Хэрэв энэхүү журмын 4.2-т заасны дагуу талууд арбитрчаа томилж чадаагүй тохиолдолд арбитрын дарга томилох бөгөөд арбитрын даргын энэ талаарх шийдвэр эцсийн байна.

4.5. Талуудын томилсон арбитрчийг арбитрын дарга батлахаас өмнө арбитрч тухайн маргааныг бие даан, хараат бус шийдвэрлэхээ баталгаажуулан мэдүүлэгт гарын үсэг зурж, хараат бус байдалд нь эргэлзээ төрүүлж болохуйц нөхцөл байдлын талаар бичгээр тайлбар гаргана. Арбитр энэ тухай мэдээллийг талуудад нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

4.6. Арбитрчийг томилсоны дараа илэрхий болсон үндэслэлээр талууд түүнийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргаж болох бөгөөд үүнийг Арбитрын тухай Монгол Улсын хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

4.7. Арбитрч нь тухайн маргааны талаар арбитрын бүрэлдэхүүний адил эрх хэмжээтэй байна.

Тавдугаар зүйл. Түргэвчилсэн хэлбэрээр явуулах арбитрын ажиллагаа

5.1. Арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулах хугацаа 30 хоногоос хэтрэхгүй байх бөгөөд шаардлагатай гэж үзвэл энэхүү хугацааг арбитрын дарга 15 хоногоос хэтрэхгүй хугацаагаар сунгаж болно.

5.2. Арбитрын дарга талуудын томилсон арбитрчийг баталснаас хойш ажлын 2 өдрийн дотор арбитрч тухайн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдамж болон дэс дараалал, хугацааг талуудтай харилцан тохиролцож тогтооно.

5.3. Тухайн маргааныг цугларсан нотлох баримтад үндэслэн шийдвэрлэх, эсхүл холбогдох нотлох баримтыг зохигчид амаар танилцуулж шийдвэрлүүлэх талаар талууд тусгайлан тохиролцоогүй бол хэрэг шийдвэрлэх ажиллагааг хэрхэн явуулахыг арбитрч өөрөө тогтоож болно.

5.4. Арбитрч гэрч, шинжээчийн тайлбарыг сонсох шаардлагатай гэж үзвэл гэрч шинжээчид асуулт тавьж, хариулт авах эрхтэй.

Зургаадугаар зүйл. Арбитрын зардал

6.1. Арбитрын ажиллагааг түргэвчилсэн хэлбэрээр явуулах зардлыг талууд “Арбитрын үндсэн болон нэмэлт зардлын хэмжээг тооцох тухай” журамд заасан хэмжээгээр төлнө.

6.2. Арбитрын шийдвэр гармагц ажлын алба нь талуудад арбитраас гарсан шийдвэрийг танилцуулах ба ийнхүү мэдэгдэхээс өмнө талууд арбитрын зардлыг бүрэн төлсөн байна.

Долоодугаар зүйл. Бусад

7.1. Энэ журамд заагаагүй бусад харилцааг Арбитрын тухай Монгол Улсын хууль болон арбитрын ердийн маргаан хянан шийдвэрлэх журамд заасан зарчмын дагуу зохицуулна.

7.2. Энэхүү журам батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.